



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 0/264

Улаанбаатар хот

Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газрын эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 06 дугаар сарын 4-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,212,899.0 /есөн сая хоёр зуун арван хоёр мянга найман зуун ерэн есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар /Б.Мөнх-Оргил/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 4,800,000.0 /дөрвөн сая найман зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 13 нэр төрлийн 4,412,899.0 /дөрвөн сая дөрвөн зуун арван хоёр мянга найман зуун ерэн есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар /Б.Мөнх-Оргил/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115070000600

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 06 дугаар сарын 08 ны өдрийн
0/364 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | НӨАУГ-ын шийдвэр |
|-------------------------------|-----------------------------------|---------------|-------------|------------|-------------|---------------------|---------------------|--------------|-----------------------------|------------------|------------------|
| Машин, тоног төхөөрөмж | | | | | | | | | | | |
| 1 | Суурин компьютер DELL i5 | 4 | ш | 3 | 31834 | 95,502.00 | 95,502.00 | - | Гацах, дэлгэц чичрэх | актлах | татах |
| 2 | Принтер Lazerjet HP1132-3 үйлдэлт | 4 | ш | 3 | 17327 | 51,981.00 | 51,981.00 | - | Цаасаа татахгүй | актлах | татах |
| 3 | Принтер Lazerjet HP1132-3 үйлдэлт | 4 | ш | 2 | 24934 | 49,868.00 | 49,868.00 | - | Цаас үрчийлгэж | актлах | татах |
| 4 | Телефон утас | 4 | ш | 6 | 51945 | 311,670.00 | 311,670.00 | - | Асахгүй. | актлах | татах |
| 5 | Суурин компьютер ALL IN ONE | 4 | ш | 1 | 181806 | 181,806.00 | 181,806.00 | - | Hard шатсан | актлах | татах |
| 6 | Принтер ML2165 | 4 | ш | 7 | 11428 | 79,996.00 | 79,996.00 | - | цаас үрчийлгэж | актлах | татах |
| 7 | Факсын аппарат | 4 | ш | 1 | 20778 | 20,778.00 | 20,778.00 | - | Давхар чимээ сонсогддог | актлах | татах |
| 8 | Өнгөт принтер SHARP A3 | 4 | ш | 1 | 2330417 | 2,330,417.00 | 2,330,417.00 | - | Хороо голж, хэвлэхээ болсон | актлах | татах |
| 9 | Проектор NEC | 4 | ш | 1 | 287197 | 287,197.00 | 287,197.00 | - | Шатсан | актлах | татах |
| 10 | Цаас хэрчигч | 4 | ш | 1 | 26000 | 26,000.00 | 26,000.00 | - | Гар хугарсан | актлах | татах |
| 11 | Хөргөгч SHARP | 4 | ш | 1 | 445122 | 445,122.00 | 445,122.00 | - | Мотор шатсан | актлах | татах |
| 12 | Хөргөгч TOSHIBA | 4 | ш | 1 | 487250 | 487,250.00 | 487,250.00 | - | Хөргөх, хөлдөөх нь | актлах | татах |
| Машин, тоног төхөөрөмжийн дүн | | | | | | 4,367,587.00 | 4,367,587.00 | - | | | |
| Тавилга, эд хогшил | | | | | | | | | | | |
| 13 | Телефон утас | 4 | ш | 3 | 15104 | 45,312.00 | 45,312.00 | - | | актлах | татах |
| Тавилга, эд хогшлын дүн | | | | | | 45,312.00 | 45,312.00 | - | | | |
| Программ хангамж | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|-----------------------------------|-----------------------------------|---|---|---|---------|---------------------|---------------------|---------------------|--|--------|--------|
| 14 | Ажлын байр, зураглалын програм | 2 | ш | 1 | 4800000 | 4,800,000.00 | 1,999,999.95 | 2,800,000.05 | | актлах | устгах |
| Программ хангамжийн дүн | | | | | | 4,800,000.00 | 1,999,999.95 | 2,800,000.05 | | | |
| Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | | | | 9,212,899.00 | 6,412,898.95 | 2,800,000.05 | | | |
| Үүнээс Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | 4,412,899.00 | 4,412,899.00 | - | | | |
| Актлах хөрөнгө | | | | | | 4,800,000.00 | 1,999,999.95 | 2,800,000.05 | | | |